



СУДАЛГАА ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ

Судалгааны сэдэв: Монгол Улсын арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа

Үндэслэл: Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах үндсэн чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь санхүүгийн салбарт учирч буй эрсдэл, тулгамдаж буй асуудлын талаар тухай бүр хуралдаанаараа авч хэлэлцэн холбогдох шийдвэрийг гарган ажилладаг билээ. СТБЗ-өөс эрсдэлийг бууруулахад чиглэсэн үр дүнтэй, оновчтой бодлогын шийдвэр гаргахад системийн эрсдэлийг эрт үед нь илрүүлж, зах зээлийн хүлээлтийг үнэн зөв тодорхойлох нь маш чухал юм.

Иймд СТБЗ-ийн Ажлын албанаас Монгол Улсын санхүүгийн системийн эрсдэлийг эрт үед нь илрүүлэхэд чухал ач холбогдолтой “Монгол Улсын арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г 2 дахь жилдээ хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран зохион байгуулах гэж байна.

Судалгааны үндсэн зорилго: Монгол Улсын санхүүгийн салбарын гол зуучлагч байгууллагууд болох арилжааны банкууд нь нийт эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал, эдгээрийн цаашдын чиг хандлагыг хэрхэн үнэлж буйг болон макро-санхүүгийн орчинд гарах болзошгүй өөрчлөлтүүд нь арилжааны банкуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх хүлээлтэй байгааг үнэн зөв тодорхойлж, үүнд үндэслэн санхүүгийн системд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, цаашид авах бодлого, зохицуулалтын арга хэмжээний саналыг боловсруулахад оршино.

Судалгааны ажлын удирдамж болон бусад шаардлагатай мэдээллийг [энэ](#) хаягаар орж үзнэ үү.

Судалгааг гүйцэтгэх саналаа ирүүлэх эцсийн хугацаа	<ul style="list-style-type: none">• 2019 оны 3 дугаар сарын 08-ны өдөр
Судалгааг гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none">• 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөрт багтаан судалгааны тайлангийн эхний хувилбарыг;• 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөрт багтаан судалгааны тайлангийн эцсийн хувилбарыг бэлтгэн захиалагч талд хүлээлгэн өгөх
Судалгааны ажлыг гүйцэтгэх үнийн дүн	<ul style="list-style-type: none">• 3 сая төгрөг

<p>Судалгаа гүйцэтгэх санал ирүүлэхэд бүрдүүлэх материалууд</p>	<p>Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны байгууллагууд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах материалыг ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны байгууллагын товч танилцуулга • Судалгаа шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлага, түүний талаарх мэдээлэл • Судалгаа шинжилгээ хийх, тайлан дүгнэлт боловсруулах мэргэжлийн боловсон хүчний танилцуулга • Судалгааг хэрхэн хийж гүйцэтгэх талаар нарийвчилсан төлөвлөгөө • Нотариатаар баталгаажуулсан байгууллагын гэрчилгээний хуулбар /1 хувь/
---	--

Нэмэлт мэдээлэл: Судалгааг гүйцэтгэх санал ирүүлэх байгууллагууд холбогдох материалаа доор дурдсан хаягаар 2019 оны 3 дугаар сарын 08-ны өдөрт багтаан (Монголбанкны бичиг хэрэгт) ирүүлнэ үү. Нэмж тодруулах аливаа асуудлаар СТБЗ-ийн Ажлын албатай 11-455122 утсаар холбогдоно уу.

Хаяг: Монголбанк, СТБЗ-ийн Ажлын алба,
Бага тойруу 3, 15160, Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг